



ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр

Монголын нэхмэлийн салбарын тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг (STeP EcoLab)

Нийт төсөв

2,320,755 Евро,
Европын Холбооны SWITCH ASIA хөтөлбөр(80%)

Хугацаа

2018-2022

Төслийн зорилтот бүлгүүд

- Нэхмэлийн салбарын ЖДҮ (~80)
- Мэргэжлийн холбоод (3)
- Малчин өрх (~5000)
- Хоршоолол ба БАХ- 30
- Төрийн байгууллагууд болон салбарын бодлого тодорхойлогчид
- Монголын боловсролын салбар (ШУТИС)
- Монгол ба Европын хэрэглэгчид (~1,500,000)
- Европ дахь нэхмэлийн компаниуд

ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Уламжлалт нүүдлийн мал аж ахуйд суурилсан ноос ноолуурын салбар нь Монголын эдийн засгийн хоёрдагч гол хөдөлгөгч хүч юм. Харин сүүлийн үед гадаадын үйлдвэрлэгчдийн өрсөлдөөн чангарч (нийлүүлэлт болон үйлдвэрлэлт) шинэ сорилтууд тулгарснаар улам бүр чанарт суурилсан үйлдвэрлэл эрхэлж, зорилтот зах зээл дахь эцсийн хэрэглэгчдийн хэрэгцээнд илүү нийцүүлэн ажиллах шаардлагатай болсон.

Монгол улсын засгийн газраас ноос ноолуурын салбарт сүүлийн жилүүдэд түлхүү анхаарч, “Тогтвортой Хөгжлийн Зорилт”-ын хүрээнд байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарал болон хог хаягдал багатай үйлдвэрлэлийн арга технологийг дэмжихийн сацуу арьс, ноос, ноолууран бүтээгдэхүүний бүрэн боловсруулалтын хэмжээг 80%-д хүргэх зорилт тавьсан. Мөн түүнчлэн, 2018 онд батлагдсан “Ноолуур Хөтөлбөр”-ийн хүрээнд байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлж, зах зээлийн хэрэгцээг хангах, өрсөлдөхүйц, ээлтэй бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх зорилт тавьжээ.

Үүнтэй зэрэгцэн олон байгууллагууд үйлдвэрлэгчээс хэрэглэгч хүртэлх гинжин хэлхээний эхлэл хэсэгт ажиллаж, өнөөгийн малчдад тулгарч буй гол бэрхшээл болох бэлчээрийн доройтод, байгаль орчны сөрөг нөлөөллөөс гарах гарцыг хайж байна.

Эдгээр шийдвэрлэх асуудлууд, сорилтууд тулгараад буй энэ үед [харилцан үр өгөөжтэй үйл ажиллагаанууд](#) (малчин өрхөөр зогсохгүй банкны салбар болон бодлогын хүрээнд) эхэлж, оролцогчдыг тогтвортой, чанарт суурилсан бизнесийн загварт шилжихийг уриалж байна.

STeP EcoLab төсөл нь дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тогтвортой түүхийн эдийн нийлүүлэлт ба үйлдвэрлэлийг гинжин хэлхээний алхам бүрт хангахад туслахын зэрэгцээ, оролцогч бүр Монгол болон Европ дахь зорилтот зах зээлд амжилттай гарах боломжийг нээхэд дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг төсөл нь нэхмэлийн салбарын боловсруулах үйлдвэрүүд **тогтвортой түүхий эдийг бэлтгэл болон үйлдвэрлэлийг** үйл ажиллагаандаа нэвтрүүлж улмаар тогтвортой бүтээгдэхүүний **брэндийг** үүсгэн бэхжүүлж, **эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, ногоон санхүүжилтын** эх үүсвэрүүдэд холбогдоход тусалж, хэрэглэгчдийн **хүрээг тэлэхэд** дэмжлэг үзүүлнэ.

STeP EcoLab төсөл Монгол улсын **нэхмэлийн салбарт тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээг бий болгохын тулд дараах хөшүүргүүдийг ашиглана**: (i) зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тогтвортой баталгаажсан түүхий эд бэлтгэх боломжуудыг үүсгэх, (ii) нэхмэлийн салбарын ЖДҮ-үүдэд тогтвортой үйлдвэрлэлийн арга туршлагыг нэвтрүүлэх таатай орчинг бүрдүүлэх, (iii) Хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд Монголын нэхмэлийн салбарын тогтвортой хөгжлийн санал санаачлагыг таниулах

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

1. Тогтвортой чанартай түүхий эдийг бэлтгэх тогтолцоог бэхжүүлэн өргөжүүлж, улмаар үйлдвэрлэгчдэд чанартай түүхий эд нийлүүлэх боломж нэмэгдэн малчин өрхийн орлого өснө.
2. Монголын ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүд өөрсдийн байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөлийг илүү сайн ойлгож, түүнийг удирдах чадавхиа хөгжүүлэн, үйл ажиллагаагаа сайжруулах хандлага бий болно.
3. Монголын ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүд одоогоор хэрэгжиж байгаа ногоон санхүүжилтийн эх үүсвэрүүдтэй холбогдон, мөн байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөллөө сайжруулах төслүүддээ санхүүжилтын эх үүсвэр олж авна.
4. Европын нэхмэлийн салбарын үйлдвэрүүд, брендүүд, Монгол-Европын хэрэглэгч үйлчлүүлэгч нарт Монголын нэхмэлийн салбарын тогтвортой хөгжлийн санал санаачлага танигдаж, тогтвортой ноос, ноолууран бүтээгдэхүүний борлуулалт нэмэгднэ.



NATIONAL FEDERATION OF PASTURE USER GROUPS OF HERDERS





switchasia
PROGRAMME




ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮС

- Улаанбаатар хот дахь үйлдвэрүүд
- Баянхонгор, Говь-Алтай, Архангай аймаг дахь ноос ноолуур, сарлагийн хөөвөр нийлүүлэгчид

ХИЙГДЭХ АЖЛУУД

1. “ХХМЭА ОУБ”, “МБАНХ”-д хамтран тогтвортой түүхий эд бэлтгэл, түүхий эдийн чанарыг хянах, сайжруулах, тогтвортой түүхий эдийг баталгаажуулах, сертификатжуулах оновчтой арга туршлагыг сурталчлах
2. Малын гаралтай ширхэгтийн эко тэмдэгжүүлэх тогтолцоог илүү таарамжтай болгон өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сурталчлах үүднээс олон талт түншүүдийн платформ зохион байгуулах.
3. CSCP ба БОАБТ нар хамтран нэхмэлийн салбарын боловсруулах үйлдвэрүүдийн байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөлийг үнэлж, түүнийг сайжруулах арга замуудыг тогтоох. МННХ-ын оролцоотойгоор салбарын тогтвортой үйлдвэрлэлийн замын зураг, сайн дурын ажиллагааны дүрмийг (Voluntary code of practice) хөгжүүлэх платформыг үүсгэн байгуулж, үйлдвэрлэгч нар тогтвортой үйлдвэрлэлийн арга барилд шилжих амлалтыг бий болгох. Түүнчлэн одоо мөрдөж байгаа хууль дүрэмд дүн шинжилгээ хийн холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг санал болгох
4. Монголын банкуудын холбоотой хамтран нэхмэлийн салбарын онцлогийг тусгасан байгаль орчин, нийгмийн эрсдлийн үнэлгээ болон бусад холбогдох гарын авлага, арга хэрэгслийг боловсруулах. Нэхмэлийн салбарын ногоон санхүүжилтийн хэрэгцээг судлах. Дотоодын болон олон улсын ногоон санхүүжилтийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг тодорхойлж, хамтран ажиллах боломжийг илрүүлэн хөгжүүлэх. МННХ-ын гишүүн байгууллагуудын ногоон санхүүжилт авах чадавхийг нэмэгдүүлэх
5. ШУТИС нэхмэлийн салбарын инженерүүдэд зориулсан “Үйлдвэрийн байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөллийн менежмент”-ийн хичээлийн агуулгыг бий болгох, түүнийг сургалтын хөтөлбөрт албан ёсоор нэвтрүүлэх, багш нарыг сургагч багшаар бэлтгэх үйл явцад дэмжлэг үзүүлэх
6. Монголын болон Европын хэрэглэгч нарын хүлээлтийг мэргэшсэн экспертийн тусламжтайгаар судлах, МННХ болон түүний гишүүн байгууллагууд тогтвортой ноос, ноолууран бүтээгдэхүүний талаар маркетинг зар сурталчилгааны материал бэлдэхэд дэмжлэг үзүүлэх, Тогтвортой бүтээгдэхүүнийг хэрэглэгч зах зээлтэй үйлдвэрлэгч, нийлүүлэгч нарыг холбох зорилгоор Монголд болон Европт худалдаа үзэсгэлэн яармаг зохион байгуулах, оролцуулах.



Зургийг: Regis Defurnaux, 2017

ХОЛБОО БАРИХ ХАЯГ

“Хил хязгааргүй малын эмч нар ба агрономчид ОУБ” – AVSF Mongolia

SWITCH STeP EcoLab Mongolia төсөл

Суурин төлөөлөгч: Quentin Moreau – q.moreau@avsf.org

Төслийн менежер: У.Сарангоо – u.sarangoo@avsf.org

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж,

MGG Properties Оффис, 4-р давхар

Утас: +976 (11) 330043 - Вэб: www.avsf.org

ХХМЭА ОУБ энэхүү хэвлэлийн эхийн агуулгыг бүрэн хариуцна. 2018

ШИЙДВЭРЛЭХ СОРИЛТУУД

- (i) Тогтвортой баталгаажсан чанартай түүхий эд нийлүүлэлтийг эрчимжүүлэх замаар малчдын байр суурийг бэхжүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг сайжруулж, орлогын эх үүсвэрийг илүү баталгаатай болгох
- (ii) Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад ноос ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх.
- (iii) Ногоон санхүүжилтийн эх үүсвэрүүдийг голлох чиг хандлага болгох замаар санхүүжилтийн олон төрлийн боломжийг ноос ноолуурын ЖДҮ-д санал болгох
- (iv) Тогтвортой нэхмэлийн салбарыг сонирхож буй бизнес эрхлэгчид хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ.



NATIONAL FEDERATION
OF PASTURE USER
GROUPS OF HERDERS

